ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

ГАРЧИГ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ	1
НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР.....	1
Тодорхойлолт	1
Гэрээний тайлбар.....	2
ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ.....	2
Бараа нийлүүлэх	2
Бараа нийлүүлэх газар	3
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	3
Барааг хүлээлгэн өгөх.....	3
Барааны гарал үүслийн улс.....	3
Баглаа боодол	3
Худалдааны нөхцөл	4
Гүйцэтгэлийн баталгаа.....	4
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ.....	4
Барааг хүлээн авах	4
Шалгалт, туршилт.....	4
Гэрээний үнэ	5
Төлбөр төлөх	5
ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА.....	5
Захиалагчийн хүлээх эрсдэл	5
Даатгал.....	5
Доголдол	6
Чанарын баталгаа	6
Алданги	6
Оюуны өмчийн эрх зөрчих	7
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал.....	7
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	7
ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ	7
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл.....	7
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл.....	8
ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ	8
Төлөөлөгч	8
Туслан гүйцэтгэгч	8
Нууцлал.....	8
Мэдэгдэл	9
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах.....	9
Маргаан шийдвэрлэх	9
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ.....	10
ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ.....	13

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй
Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Бараа нийлүүлэх газар	2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6. Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
	2.7. Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
	2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
	2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
	2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Барааг хүлээлгэн өгөх	2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
	2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
	2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

- 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
- Худалдааны нөхцөл**
- 2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
- 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- Гүйцэтгэлийн баталгаа**
- 2.19. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Нийлүүлэгч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 2.20. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
- 2.20.1. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
- 2.20.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
- 2.20.3. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 2.21. Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 2.22. ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 2.23. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

- Барааг хүлээн авах**
- 3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
- Шалгалт, туршилт**
- 3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ** 3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх** 3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

- Захиалагчийн хүлээх эрсдэл** 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
 - 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
 - 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал** 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс

хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдол

- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
- 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
- 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
- 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Чанарын баталгаа

- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
- 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
- 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
- 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Алданги

- 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа

- хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
- Оюуны өмчийн эрх зөрчих** 4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал** 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
- Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа** 4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл** 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
- 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
- 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн

хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

**Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах мэдэгдэл**

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

Нууцлал

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл

- хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
- Мэдэгдэл**
- 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:
- 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;
- 6.15.2. үнийн тохируулга хийсэн.
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- Маргаан шийдвэрлэх**
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар:</p> <p><i>Хавдар судлалын үндэсний төв, Эм зүйн алба</i></p>
ГЕН 2.6.	<p>Бараа нийлүүлэх хугацаа:</p> <p><i>Нийлүүлэлтийн хуваарийн дагуу.</i></p>
ГЕН 2.10.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p><i>Хуваарийн дагуу.</i></p>
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:</p> <p><i>Нэмэлт шаардлагууд нь Техникийн тодорхойлолтод тусгагдсан. Стандарт савлагаатай</i></p> <p>Баглаа, боодлын шаардлага:</p> <p><i>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна.</i></p>
ГЕН 2.17.	<p><i>Жишиг заалтууд (CIP нөхцөл)</i></p> <p><i>Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:</i></p> <p>Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.</p> <p>Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, ачсан боомт, боомтоос гарах огноо, тээврийн хэрэгслийн нэр, буулгах боомт зэргийг дурдана.</p> <p>Нийлүүлэгч дараах баримт бичгийг⁸ захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ: Барааг онгоцоор тээвэрлэх тохиолдолд нислэгээс дор хаяж 48 цагийн өмнө тээврийн хэрэгслийн нэр, нислэгийн дугаар, бараа ирэх хугацаа, тээврийн баримтын дугаар зэргийг захиалагчид мэдэгдэнэ.</p> <p>Захиалагч мэдэгдлээ факсаар ирүүлж дараах баримт бичгийг захиалагчид, хуулбарыг даатгалын компанид баталгаат шуудангаар хүргүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. нийлүүлэгчийн нэхэмжлэхийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувь. Үүнд захиалагчийн нэр, хаяг <i>[гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих]</i>; гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг зааж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна; 2. Захиалагч <i>[гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих]</i> болон гэрээнд заасан бусад мэдэгдэх байгууллагыг дурдаж, Техникийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувийг болон бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 2 ширхэг хуулбар хувийн хамт; эсхүл

⁸ Инкотермсын аль нөхцөлийг ашиглахаас үлдэн бусад зохих баримт бичгийн нэрийг жагсаана.

	<p>Техникийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий 3 хувь баримт</p> <ol style="list-style-type: none"> 3. барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт; 4. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар; 5. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг хуулбар хувь 6. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн Шалгалтын гэрчилгээний үндсэн хувь; 7. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг 8. “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар <p>Монгол улсын дотроос нийлүүлэх барааны хувьд:</p> <p>Гүйцэтгэгч бараа хүрэлцэн ирэхэд эсхүл ирэхээс өмнө захиалагчид бичгээр мэдэгдэж дор жагсаасан баримт бичгийг захиалагчид өгсөн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан нийлүүлэгчийн нэхэмжлэхийн хувь; 2 ширхэг үндсэн, 2 ширхэг хуулбар хувь 2. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн бараа хүргэсэн баримт, 2 хувь 3. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар 4. Барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт; 5. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг үндсэн хувь 6. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн шалгалтын гэрчилгээний хуулбар хувь; 7. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг 8. “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар <p>Санамж: Нийлүүлэгчийн ирүүлсэн баримт бичиг нь гэрээний шаардлагад нийцэхгүй бол төлбөрийг ГТН-ийн 9 (ГЕН 9)-ийн дагуу хийх шалгалт туршилтын дүнг үндэслэн төлнө.</p>
ГЕН 3.8.	<i>Үнийн тохируулга хийх аргачлал: Тохируулахгүй тогтмол байна.</i>
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p>Энэ гэрээний дагуу гүйцэтгэгчид хийх төлбөрийг дараах нөхцөлөөр хийнэ.</p> <p>Монгол улсын гаднаас санал болгосон барааны төлбөр:</p>

	<p>Гадаад валютаар хийх төлбөр нь <i>[гэрээний үнийн валютыг оруулах]</i>-аар дараах байдлаар төлөгдөнө:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Урьдчилгаа төлбөр:</u> Хийхгүй 2. <u>Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</u> Хийхгүй 3. <u>Барааг хүлээн авч гүйцэтгэл гарахад төлөх:</u> 100% <p>Төгрөгөөр хийх төлбөр нь нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай акт ирснээс хойш 45 хоногийн дотор төлөгдөнө.</p> <p>Монгол улсын дотроос санал болгосон барааны төлбөр:</p> <p>Монгол улсын дотроос нийлүүлсэн барааны төлбөр нь <i>[гэрээний үнийн валютыг оруулах]</i>-аар дараах байдлаар хийгдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Урьдчилгаа төлбөр:</u> Хийхгүй 2. <u>Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</u> Хийхгүй 3. <u>Барааг хүлээн авч гүйцэтгэл гарахад төлөх:</u> 100%
ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p><i>Гэрээ нь СИР үнэд үндэслэсэн тохиолдолд даатгал нь “агуулахаас агуулахад” дайн болон ажил хаялтыг оруулсан “бүх эрсдэл” нөхцөлтэй, СИР үнийн 110 %-ийн дүнтэй байна.</i></p>
ГЕН 4.10.	<p>Баталгаат хугацаа:</p> <p><i>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол Тендерийн баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]</i></p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа:</p> <p><i>Гэмтэлтэй барааг солих хугацаа: 14 хоногийн дотор</i></p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: <i>Тийм</i></p> <p>Алдангийн хувь: <i>Хоног тутамд 0.3%</i></p>
ГЕН 4.18.	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: <i>Үгүй</i></p>
ГЕН 16.15	<p><i>Гэрээний хүчинтэй байх хугацаанд хуваарьт заасан нийлүүлэлт дууссан эсхүл төсвийн жил шилжиж дараагийн жилийн худалдан авах ажиллагааны хуулийн мөрдөгдөх хугацаанд эмчилгээ, үйлчилгээг таслахгүй, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гэрээний үнээр, нийт үнийн дүнгийн 20 ба түүнээс бага хувьд нэмэлт худалдан авалт хийж болно.</i></p> <p><i>Нэмэлт худалдан авалт хийх тохиолдолд Гэрээний нэмэлт өөрчлөлт хийх ба уг нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.</i></p>

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “Нийлүүлэгч” гэх) нь **[бараа үйлчилгээний товч тодорхойлолт]**-ыг нийлүүлэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Баталгаа гаргасан,

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг:

Гүйцэтгэлийн баталгааны маягт

(Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]** нь (цаашид “Нийлүүлэгч” гэх) **[бараа, үйлчилгээний товч тодорхойлолт]**-ыг нийлүүлэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г⁹ үндэслэн баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлөх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Үнэт цаасыг Захиалагчийн нэр дээр шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Баталгаа гаргасан,

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга:

Огноо:

Хаяг:

⁹ Засгийн газрын бондын болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь гэрээний хэрэгжиж дуусах хугацаанаас 3-аас доошгүй сарын дараа байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2023 оны 04 дүгээр сарын 05 өдөр

Тендер шалгаруулалтын **Хавдар судлалын үндэсний төвд эм,**
нэр: **эмнэлгийн хэрэгсэл, оношлуур нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын **НОННХСҮТ/202302001**
дугаар:

Хавдар судлалын үндэсний төв нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг 2023 онд Хавдар судлалын үндэсний төвд эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур нийлүүлэх нээлттэй тендерийг ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

- 1-р багц. Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл
- 2-р багц. Мансууруулах үйлдэлтэй эм бэлдмэл 1
- 3-р багц. Мансууруулах үйлдэлтэй эм бэлдмэл 2
- 4-р багц. Протон шахуургын ингибиторууд
- 5-р багц. Дотоодын үйлдвэрийн эм-1
- 6-р багц. Цус орлох сийвэн
- 7-р багц. Мэдээгүйжүүлэх үйлдэлтэй эм бэлдмэл
- 8-р багц. Мэдээгүйжүүлэх үйлдэлтэй эм бэлдмэл
- 9-р багц. Карбапенем болон MRSA эсрэг бэлдмэл
- 10-р багц. Антибиотик ба мөөгөнцрийн эсрэг эм бэлдмэл
- 11-р багц. Эмэгтэйчүүдийн практикт хэрэглэх эм бэлдмэл
- 12-р багц. Зүрх судасны болон даралт бууруулах эм бэлдмэл
- 13-р багц. Зүрх судасны болон даралт бууруулах эм Калцийн сувгийг дарангуйлах
- 14-р багц. Хими, туяа эмчилгээний үеийн бөөлжилтийн эсрэг эм
- 15-р багц. Хими, туяа эмчилгээний үеийн бөөлжилтийн эсрэг эм
- 16-р багц. Дааврын болон цус бүлэгнэлтэд нөлөөлөх эм бэлдмэл
- 17-р багц. Цус бүлэгнэлтэд нөлөөлөх эм бэлдмэл антифибринолитик
- 18-р багц. Мансууруулах эм
- 19-р багц. Хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх эм бэлдмэл
- 20-р багц. Дотоодын эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн-2
- 21-р багц. Туяаны хордлого тайлах шингэн
- 22-р багц. Судсаар болон гуурсаар хооллох хүнс тэжээл
- 23-р багц. Элэг хамгаалах, антиоксидант бэлдмэл
- 24-р багц. Яаралтай тусламж үйлчилгээнд хэрэглэх бэлдмэл
- 25-р багц. Тарианы уусгагч бэлдмэл Дотоодын үйлдвэр-3

- 26-р багц. Тосон түрхэц
- 27-р багц. Спиртэт нэгдэл Дотоодын үйлдвэр-4
- 28-р багц. Халдваргүйтгэл ариутгалын Дотоодын үйлдвэр-5
- 29. Гемодиализийн эмчилгээний бэлдмэл, гуурс, шүүлтүүрийн хэрэгсэл/ Дотоод 6/
- 30. Дурангийн багц
- 31. Дурангийн мэс ажилбарын тодосгогч
- 32. Тархины цусан хангамж сайжруулах эм бэлдмэл
- 33. Багц Сэтгэц нөлөөт эм бэлдмэл
- 34. Багц Цус тогтоох эм бэлдмэл
- 35-р багц. Нитроген аналог агуулсан хавдрын эсрэг эм, бэлдмэл /L01A/
- 36. Ясны бүтцэд нөлөөлөх эм M05BA08
- 37-р багц. Фолийн хүчил агуулсан хавдрын эсрэг эм бэлдмэл
- 38-р багц. Алкилат аналог агуулсан хавдрын эсрэг эм бэлдмэл /L01AX/
- 39-р багц. Пиримидины аналог агуулсан хавдрын эсрэг эм, бэлдмэл /L01BC: L01XX/
- 40-р багц. Алклойд агуулсан хавдрын эсрэг эсрэг эм бэлдмэл /L01CB; L01CA/
- 41-р багц. Платин агуулсан хавдрын эсрэг эм бэлдмэл /L01XA/
- 42. Цитотоксик антибиотик
- 43-р багц. Химийн антибиотик эм бэлдмэл /L01D/
- 44-р багц. Химийн антибиотик эм бэлдмэл /L01D/
- 45-р багц. Цус төлжүүлэгч фактор
- 46-р багц. Цус, цусны бүрэлдэхүүнд нөлөөлөх эм
- 47-р багц. Иммуномодулятор пиримидины аналог /L01BC52/
- 48-р багц. TOP regimen 1.FOLFOX+2.(taxan,cddp)+3.FOLFIRI
- 49-р багц. Элэг болон химийн хордлого тайлах
- 50-р багц. Нэг удаагийн үзлэгийн бээлий
- 51-р багц. Нэг удаагийн люэр түгжээтэй тариур
- 52-р багц. Нэг удаагийн тариур
- 53-р багц. Нэг удаагийн тариур, зүү
- 54-р багц. Дуслын систем
- 55-р багц. Автомат биопсийн зүү 1
- 56-р багц. Туяа эмчилгээнд шаардлагатай хэрэгсэл
- 57-р багц. Мэс заслын ариун халад /inforced/
- 58-р багц. Нөхөн сэргээх мэс засал
- 59-р багц. Рентген хальс, хор
- 60-р багц. Нэг удаагийн мэс заслын утас
- 61-р багц. Нэг удаагийн мэс заслын утас, зүү
- 62-р багц. Мэс заслын ариун бээлий

- 63-р багц. Боолт, жижиг ажилбаруудын ариун бээлий
- 64-р багц. Мэс заслын нэг удаагийн хэрэгсэл 1
- 65-р багц. Мэс заслын нэг удаагийн хэрэгсэл 2
- 66-р багц. Хагалгаа, мэдээгүйжүүлгийн нэг удаагийн хэрэгсэл
- 67-р багц. Биопсийн нэг удаагийн хэрэгсэл
- 68-р багц. Мэдээгүйжүүлэгт хэрэглэх нэг удаагийн хэрэгсэл 1
- 69-р багц. Мэдээгүйжүүлэгт хэрэглэх нэг удаагийн хэрэгсэл 2
- 70-р багц. Химийн порт
- 71-р багц. Амбулаторийн үзлэгийн нэг удаагийн хэрэгсэл 1
- 72-р багц. Амбулаторийн үзлэгийн нэг удаагийн хэрэгсэл 2
- 73-р багц. Шархны наалт, нэг удаагийн хэрэгсэл
- 74-р багц. Цус тогтоох хэрэгсэл
- 75-р багц. ESCO safety cabinet /model CYT-4A1 filter /
- 76 -р багц Биопсийн нэг удаагийн хэрэгсэл -2
- 77 -р багц. Мэдээгүйжүүлэхэд хэрэглэх өвөрмөц хэрэгсэл
- 78 -р Багц. Эмэгтэйчүүдийн нэг удаагийн хэрэгсэл
- 79 -р багц Урт хагалгаанд хэрэглэх хэрэгсэл
- 80-р багц. Ариутгал, халдваргүйжүүлэх бодис
- 81-р багц.Дурангийн халдваргүйтгэл, ариутгалын уусмал
- 82-р багц. Халдваргүйжүүлэх бодис
- 83-р багц.Плазма ариутгалын аппарат дагалдах хэрэгсэл / Shinwa ps100x/
- 84-р багц. Багаж, хэрэгсэл ариутгах хэрэгсэл /уурын/
- 85-р багц. Ороох боох материал
- 86-р Багц. Дотоодын үйлдвэрлэл – 7
- 87-р Багц. Дотоодын үйлдвэрлэл
- 88-р Багц. Халдвар хамгаалалын индикаторууд
- 89-р багц Гар ажиллагаагаар хийх иммуногистохими
- 90-р багц Автомат /Ventana-Bench Mark GX/ иммуногистохими
- 91-р багц. Гистологи, цитологийн лабораторийн урвалж
- 92-р багц. Гистологи, цитологийн тусгай будаг
- 93-р Багц : Биохимийн 1 лабораторийн урвалжийн захиалга
- 94-р Багц : Биохимийн 2 лабораторийн урвалжийн захиалга
- 95-р Багц: Клиник гематологийн лабораторийн урвалжийн захиалга
- 96-р Багц Вирус молекул биологи
- 97-р Багц: Вирусын болон гормон хамааралт хавдрын оношилгоо
- 98-р Багц : Лабораторийн нэг удаагийн хэрэгслийн захиалга
- 99-р Багц: Клиник гематологийнхагас автомат шинжилгээ

100-р Багц: Хавдрын маркер

101 -р Багц: Хавдрын маркер 2

102-р Багц: Эмнэл зүй молекул биологийн лабораторийн чанарын гадаад хяналтын материал худалдан авах зардал

103-р Багц: Бактериологи лабораторийн урвалж бодисын захиалга

104-р багц Хорт хавдрын эрт илрүүлгийн багц 1

105-р багц Хорт хавдрын эрт илрүүлгийн багц 2

106-р багц. Цус, цусан бүтээгдэхүүн

107-р багц. Хүчилтөрөгч, нүүрсхүчлийн хий

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендерийг **2023 оны 05-р сарын 05-ны өдрийн 10 цаг 30 минут**–аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2023 оны 05-р сарын 05-ны өдрийн, 11 цаг 00 минут**-нд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхтэй”**

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: **“Үгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Хүлээн авагчийн нэр: **Ж.Жавхлан, Эм зүйн албаны дарга**

Хаяг: **Хавдар судлалын үндэсний төв, 1-р давхар**, Утасны дугаар: **99060704**, факс: **458189**

Цахим шуудангийн хаяг: **javkhlan@cancer-center.gov.mn**